

# “ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 29 ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

## Компанийн 2016 оны санхүүгийн тайлан, тэнцэлд аудитын дүгнэлтийг тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11, компанийн дүрмийн 9.3.8, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 2.9.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Тус компани 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн аудитын зөвлөмжид 3 542,6 сая төгрөгийн хойшлогдсон орлогыг орлогоор бүртгэж тайлагнаагүй, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу явуулаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 69,6 сая төгрөгөөр дутуу тооцсон зэрэг зөрчлүүдэд хязгаарлалттай санал дүгнэлт гаргасан тул зөвлөмжийг хэрэгжүүлж, цаашид санхүүгийн зөрчил гаргахгүй ажиллахыг гүйцэтгэх захирал /Д.Балдорж/-д үүрэг болгосугай.

2. Санхүүгийн тайлан тэнцлийн аудитын хязгаарлалттай дүгнэлт гаргах зөрчил үүсгэсэн холбогдох ажилтанд хариуцлага тооцохыг гүйцэтгэх захирал /Д.Балдорж/-д даалгасугай.

3. ЭХЗХ-нд хандаж нэгдсэн системийн нэг худалдан авагчийн загварын хуваарилагдаагүй үлдсэн 3 347,6 сая төгрөгийг байгууллагын ашигт тооцохгүй байх шийдвэр гаргуулахыг гүйцэтгэх захирал /Д.Балдорж/-д даалгасугай.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороонд компанийн сүүлийн 2 /хоёр/ жилийн санхүүгийн тайлан тэнцэлд өгсөн аудитын дүнг харьцуулсан байдлаар танилцуулж дүгнэлт гаргуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахыг Санхүү эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс /Б.Баярцэнгэл/-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.ЧИМЭДДОРЖ

ТТД № 4573